

## “Ногоон нуур цэцэрлэгт хүрээлэн” ТББ-ын танилцуулга

Чингэлтэй дүүгийн 12 хорооны иргэн С.Өлзийтогтох 2009 оны 8 сард өнөөдрийн “Ногоон нуур цэцэрлэгт хүрээлэн”-ийн газрыг гэр хорооллын айлуудын хогийн цэг байхад нь олж харж хуучин “Нуурыг сэргээн” мод тарих, иргэдийн чөлөөт цагаа өнгөрүүлэх газар болгохоор хувийн хөрөнгө оруулалтаар хөгжүүлж ирсэн.

Тухайн газраас 1946-1947 онуудад японы олзлогсод Улаанбаатар хотод Сүхбаатарын талбай, хотын төв замын чулууг бэлтгэж байсан. 1947-1950-аад оны сүүлч хүртэл монгол хоригдлууд зам барихад шаардлагатай хайрга чулууг мөн бэлтгэж байжээ. Дээр үеийн “Чулуун тоочиг” буюу өнөөдрийн “Ногоон нуур цэцэрлэгт хүрээлэн” байгаа газраас замын чулууг 1950-аад оны сүүлчээс бэлтгэхээ больж эзгүй хаягдсан нь олон жилийн турш борооны ус хуралдан хад руу болон усруу мал амьтан унаж осолдох аюултай орчин болсон байсан.

2000-аад оны үеэс Улаанбаатар хотод ирэх хөдөөний айлуудын их нүүдэл, төвлөрөл, гэр хорооллын тэлэлтээс шалтгаалан яваандаа хур хогийн цэг болж борооны усаар тэжээгдсэн “Нуур” ширгэж шалбааг төдий болсныг иргэн Өлзийтогтох, ихэвчлэн хуванцар хог хаягдал бүхий бохирдлыг цэвэрлэснээр борооны усанд Нуур цөөрөм сэргэж өвөлдөө тэшүүр, зун завиар гэр хорооллын иргэд тоглох боломжтой болсон.

Ажилгүйдэл, ядуурал элбэг гэр хорооллын иргэдэд маш хямд үнээр олон жилийн турш үйлчилж ирсэн тус газар нь Төрийн болон ямар нэг хувийн байгууллагаас санхүүждэггүй, зөвхөн улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг завь, тэшүүрийн орлогоос санхүүжиж ирсэн. Одоо Ногоон нуур цэцэрлэгт хүрээлэнд өвөлдөө тэшүүр тоглохоор давхардсан тоогоор 9,000-10,000 орчим хүүхэд залуучууд ирдэг. Зуны улиралд 2000 орчим хүмүүс гэр бүл, найз нөхдийн хамтаар ирж завиар тоглох, туршлага судлах, дотоод, гадаадын иргэд аяллаар ирж танилцах мөн 2013 оноос өдийг хүртэл монголын хэвлэл мэдээллийн байгууллагууд нийгэмд сайн жишээ болгон түгээсээр байдаг. /та google –ээс Ногоон нуур цэцэрлэгт хүрээлэн, Уулын нуур гэж хайвал гарч ирнэ/

Ногоон нуураас 2012 онд 300 орчим шуудай хог цэвэрлэж 2013-2019 он хүртэл хавар, намрын улиралд мод тарьсаар одоо нэг га газарт 20 орчим төрлийн 1000 гаруй мод, бут ургуулж Нуурын уснаас модоо усалж байгалийг нөхөн сэргээж байна. Дээрх модны 50% орчмыг Өлзий, бусад хэсгийг дотоод, гадаадын иргэд өөрсдийн дурсгалын мод болгон тарьсан байдаг.

2019 оноос эхлэн Ногоон нуур цэцэрлэгт хүрээлэнд зуны улиралд бага, дунд насны хүүхдэд зориулсан номын сан, леги тоглоом, гадаад хэл, уран зураг, хөгжмийн боловсрол олгох сургалтуудыг ойр орчмын айл өрхийн хүүхдүүдэд зориулан явуулсаар байна. Учир нь иргэдэд зориулсан дэд бүтэц муу хөгжсөн, тэр тусмаа Олон нийтийн төв ойр орчимд Ногоон нуураас өөр байхгүй байсаар байна.

Иргэн С.Өлзийтогтохын санаачлан, хувийн хөрөнгө оруулалтаар хөгжүүлсээр ирсэн Ногоон нуур цэцэрлэгт хүрээлэнд 2019 оноос хойш дотоод, гадаадын уран бүтээлчид Хог хаягдлыг дахин ашиглан бүтээл хийх, жазз хөгжмийн тоглолт, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах зэргээр хамтран ажилласаар байна.

Улаанбаатар хотын түүхэн дурсгалтай холбоотой дээрх газарт Өлзийтогтох цаашид Музей байгуулах, Хүүхэд хөгжлийн төвөө өргөжүүлэх, иргэд болон жуулчид тав тухтай суух кофе шоп байгуулах, зуны шөнө “усан дээрх кино” гаргах зэрэг ажлуудыг төлөвлөн бага, багаар хэрэгжүүлсээр байна.

# Мод тарих ажлын хэсгээс /2013-2019 он/

Нуурын ус сэргэж мод тарихад бэлэн болов  
2013 оны зун



**Сүхбаатарын талбай /1946 он/**



**Нуурын ёроолын хэсэг /2010 он/**



**Хог цэвэрлэж буй үе /2012 оны 4 сар/**



**Хөрсийг гаргаж мод тарьж эхлэв /2012/**



**2012 оны хавар хогийг цэвэрлэж зуны  
борооны усанд Нуурын ус сэргэн өвөл  
нь тэшүүрээр хүүхдүүд тоглох  
боломжтой болов  
/Зураг 2012 оны 11 сар/**



**Америкын цэргийн Жазз хөгжмийн  
Тоглолт /2022.06.30/**



**Үлгэрийн цаг**

**Франц, Герман, Амрик зураачид байшин  
болон бусад хэсгийг будав /2019/**



**Усан дээрх кино /2021 он/**

**Европын Жазз хөгжимчид тоглолт хийв  
/2021 оны 8 сар /**



**Нээлттэй микрофон /2022.9 сар/**



**Гэр музейн нээлт /2022.08.04/**



**Хүүхдийн урлагийн тоглолт /2022.09.03/**



**Европын соёлын сангийн төсөл хэрэгжив  
/2021.04 сар/**



Гадуурх тарифаас 50-70% хямд тоглуулж ирсэн



Англи жуулчид

Орос жуулчид /2022 он/



АНУ-ын Элчин сайд Ричард Буанган

Бельги жүжигчин  
Tom Waes



Англи сэтгүүлч



Израиль жуулчид



Жуулчид



Их сургуулийн оюутнууд



**“Ногоон нуур цэцэрлэгт хүрээлэн”-д жил бүрийн зун явагддаг  
лего тоглоом, номын сан болон бусад сургалтууд**



**2010-2022 онд Уулын нуурт хийгдсэн бүтээн байгуулалт, газрын татвар төлбөр зэрэгт нийт 300,000,000 сая орчим төгрөг зарцуулсан**

1. Хоёр давхар 176 мкв сургалтын байшин
2. 2-оос 3 давхар 700 метр газарт төмөр торон хашаа, хайс хийгдсэн
3. Урд, баруун талд 2 хаалга үүд хийгдсэн
4. Урд, баруун талын үүд хэсэгт Нуур руу орох төмөр болон модон шат хийгдсэн
5. Нуур тойруулан 110 м урт 1 м 20 см өргөн модон тавцан хийгдсэн
6. Гэрэлтүүлэг 8 газарт хийгдсэн
7. Гадна 4 ш, дотор 4 ш камержуулалт хийгдсэн
8. Завь 18 ш Хятадаас авчирсан
9. Тэшүүр 10 жилийн хугацаанд 1,000 орчмыг хятадаас худалдан авч байсан
10. Том жижиг нийт 8 ш сүүдрэвч
11. Тайз 1 ш
12. Нуурын эрэгт хүмүүс суух урт нь 8 м, өргөн нь 4 м Усан завь 1 ш
13. Нуурыг усыг 3 жил дараалан шинжилгээнд өгч байсан
14. Жил бүрийн газрын төлбөр, татварууд
15. Био ариун цэврийн байгууламжууд
16. Ажилчдын цалин
17. Европын соёлын сангийн хөрөнгө оруулалт
18. Төрийн байгууллагын дэмжлэг мөнгөн дүнгээр
19. Хот харах өндөрлөг хэсгийн тавцан
20. Тарьсан моднууд нийт 20 орчим төрлийн 1000 орчим мод, бут
21. Бага, дунд насны хүүхдийн номын сан
22. Бага, дунд насны хүүхдэд зориулсан леги болон сэтгэхүй хөгжүүлэх тоглоом
23. Хүүхдийн сургалтын өрөөний тохижилтууд
24. Монгол дахь АНУ-ын ЭСЯ-ны Орон нутгийг дэмжих хөрөнгө оруулалт
25. Уулын нуурын эргэн тойронд машин зогсоол, хот харах хэсэг, музей хийх, иргэд суух талбай зэрэг 7 айлын газар худалдан авсан
26. Хүүхдийн сургалтанд хэрэглэх төгөлдөр хуур, гитар, морин хуур, хийлүүд
27. 4 м өндөр гаднах гацуур
28. Нуур тохижуулж эхлэх үеийн газар шорооны ажил, техник хөлсөлж байсан
29. Жил бүр гарах бохир ачуулах зардлууд
30. Жил бүр цэвэрлэх шаардлагатай шар өвс, шарилж цэвэрлэх ажлууд гэх мэт

Уулын нуур хийгдсэнээр нөлөөллийн ажлууд  
2013-2022 он хүртэл Хэвлэл мэдээллийн байгууллага Сайн жишээ болгон байнга олон нийтэд  
сурталчилж, нэвтрүүлж ирсэн  
Уулын нуур руу Улсын төсвөөр тавигдсан засмал зам 100 м орчим  
Засмал зам дагуух 40 айлд Улсын төсвөөр Био 00, хогны сав тавигдсан

Уулын нуурын үнэ тариф

## ҮНЭ ТАРИФ

ЗАВЬ	70кг 50кг 40кг	хүүхэд	15 мин 1000 30 мин 2000	45 мин 3000 1цаг 4000
		ТОМ ХҮН	15 мин 2000 30 мин 4000	45 мин 6000 1цаг 8000



Өдөр бүр: 10:00 – 20:00

 [Uuliin Nuur Park](#)